



Квази вариацийн тэнцэтгэл бишийн хувьд динамик системтэй холбогдох алгоритмын судалгаа

Суурь судалгааны төслийн тайлан

2022 он

Төслийн удирдагч:

Л.Алтангэрэл, доктор (PhD), МГТИС-ийн
профессор

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Гарчиг

1	Оршил	5
2	Квази вариацийн тэнцэтгэл биш ба Ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн бодлого	10
2.1	Квази вариацийн тэнцэтгэл бишийг бodoх алгоритм	10
2.2	Хамтын зааглалттай ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загварын зэсийн зэх зээл дэх хэрэглээ	11
2.2.1	Сонгодог Нэшийн тэнцвэрийн загвар ба вариацийн тэнцэтгэл биш	11
2.2.2	Хамтын зааглалттай ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загвар . . .	12
2.2.3	Зэсийн зах зээл дэх хэрэглээ ба вариацийн тэнцэтгэл бишийн томъёолол	12
3	Төлбөрийн чадварын зааглалттай даатгалын хураамжийн загвар	15
3.1	Нэг үет даатгалын загвар	15
3.2	Нэг үет загварын өргөтгөл	16
3.3	Тоон туршилт	18
4	Төлбөрийн чадварын зааглалттай банкны зээлийн хүүгийн загварууд	19
4.1	Төлбөрийн чадварын зааглалттай банкны загвар	19
4.2	Тоон туршилт	24
5	Нийлмэл Нэгэн Төрлийн Бус Пуассоны Процесс Дээр Суурилсан Стохастик DDM	26
5.1	Аргачлал: Нийлмэл Нэгэн Төрлийн Бус Пуассоны Процесс	26
5.1.1	Ноогдол ашиг	26
5.1.2	Дефолт болох магадлал	27
5.1.3	Хувьцааны санамсаргүй үнэ	28
5.1.4	Параметрүүдийн хамгийн их үнэний хувь бүхий үнэлэлт	30
5.2	Тоон туршилт	32
5.3	Хавсралтууд	34

Төслийн багийн гишүүд

N	Нэрс	Албан тушаал
1	Др. Л.Алтангэрэл	МГТИС-ийн профессор
2	Др. Г.Баттөр	МУИС-ийн ХШУИС-ийн багш
3	Др. Г.Баттулга	МУИС-ийн ХШУИС-ийн багш
4	Г.Доржсундуй	МГТИС-ийн багш, магистр

Төслийн хүрээнд тавигдсан зорилтууд

1. Зааглалт нь шилжигч олонлог байх тохиолдолд квази вариацийн тэнцэтгэл бишийн хувьд динамик системтэй холбогдох алгоритм боловсруулж, нийлэлтийг нь батлан, тоон туршилтаар баталгаажуулна.
2. Шугаман хамтын зааглалттай ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн бодлогын хувьд уг алгоритмыг туршиж, холимог ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн бодлогын хувьд гарган авсан зааг функцийн чанаруудыг судлах замаар тохирох алгоритмыг санал болгоно.
3. Хөрөнгийн даатгалын хувьд гарган авсан олон үет загварыг ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загварт шилжүүлэх үндэслэлийг гаргаж, тоон туршилтаар баталгаажуулан, практикт хэрэглэх зөвлөмжийг боловсруулна.
4. Хувьцааны ханинийг таамаглах VAR загварыг санал болгож, түүний багцын сонголт болон тоглоомын онолтой хэрхэн холбогдох судалгааг хийнэ.

БҮЛЭГ 1

Оршил

Квази вариацийн тэнцэтгэл биш нь оптимизацийн бодлогын шийд оновчтой байх нөхцөл, гүйцээлтийн бодлого, вариацийн тэнцэтгэл биш, шугаман бус тэгшитгэлийн систем зэрэг бодлогуудын өргөтгөсөн хэлбэр болохоос гадна дурс боловсруулалт, хүрээлэн буй орчны бодлого, сүлжээний бодлого зэрэг хэрэглээтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд эрчимтэй судлагдаж байна. Мөн стратегийн олонлог нь бусад тоглогчдын стратегиас хамаардаг ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загвар нь тоглогч бурийн хожлын функц дифференциалчлагддаг тохиолдолд квази вариацийн тэнцэтгэл биш рүү шилждэг. Тухайн бодлогын хүндрэл нь зааглалтын олонлог нь хувьсагчаас хамаарсан олонлог утгат буулгалт байдагтай холбоотой. Энэ төслийн хүрээнд тавигдсан нэг зорилт нь сүүлийн жилүүдэд динамик системтэй холбоотойгоор оптимизацийн болон вариацийн тэнцэтгэл бишийн хувьд эрчимтэй судлагдаж буй аргуудыг судалж, зааглалт нь шилжигч олонлог байх тохиолдолд квази-вариацийн тэнцэтгэл бишийн хувьд шинэ алгоритм боловсруулж, нийлэлтийг нь батлан улмаар ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн бодлогын тодорхой ангиid хэрэглэх явдал юм. Түүнээс гадна өмнө хийгдсэн квази-вариацийн тэнцэтгэл бишийн хувьд зааг функцтэй холбоотой судалгааг үргэлжлүүлэхээс гадна санхүүгийн зах зээл дэх тоглоомын онолын болон дискаунчлагдсан ноогдол ашгийн загвартай холбоотой зарим үр дүнг гарган авахаар төлөвлөсөн.

Төслийн хүрээнд тавигдсан зорилттой холбоотойгоор хийгдсэн судалгаа болон ажлуудыг тоймлон хүргэвэл:

2018 он:

- Судалгааны сэдэвтэй холбоотойгоор багийн гишүүд оролцсон судалгааны семинарыг тогтмол явуулснаас гадна динамик системтэй холбогдох оптимизацийн болон вариацийн тэнцэтгэл бишийн зарим алгоритмын талаар илтгэлийг төслийн удирлагч Л.Алтангэрэл 2018 оны 11-р сарын 17-нд МУИС-д болсон "Хэрэглээний математик 2018" эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн.
- Мөн 2018 оны 12-р сарын 17-19-нд Австрийн Венийн их сургуульд зохион байгуулагдсан "The Vienna Workshop on Computational Optimization" олон улсын хуралд Л.Алтангэрэл оролцож, квази вариацийн тэнцэтгэл бишийн зааг функцийн талаар гаргасан үр дүнгийн талаар хэлэлцүүлсэн. Уг олон улсын хуралд АНУ, Канад, ХБНГУ зэрэг улсын оптимизаци, загварчлалын чиглэлийн нэр хүндтэй эрдэмтэд уригдсан илтгэл хэлэлцүүлснээс гадна Австри, Герман, Итали, Франц, Швед, Монгол зэрэг орны их сургуулиудад ажиллаж буй судлаачид өөрсдийн судалгааны үр дүнгээ танилцуулсан. Тухайлбал энэ хурлын үеэр Канадын Бритиш Колумбиын их сургуулийн профессор Баушке, Австрийн Венийн их сургуулийн профессор Бот нартай уулзаж, энэ төслийн хүрээнд тавигдсан зорилтуудыг биелүүлэхэд хэрхэн хамтран ажиллах талаар ярилцсан.
- Даатгалын салбарт тоглоомын онолыг хэрэглэх судалгаа нэлээд эртнээс эхэлсэн бөгөөд даатгалын компаниуд хураамжaa тогтоодог Берtrandын эсвэл нөхөн төлбөрийн оновчтой хэмжээг тогтоодог Курногийн гэсэн 2 загварт хуваан

үзэж болно. 2013 онд Дутанг нар тоглогч бүр даатгуулагчтай хийх гэрээг шинэчлэх замаар ашгаа хамгийн их байлгах Нэшийн тэнцвэрийн загварыг санал болгосон. Мөн уг загварт тоглогч бүрийн өөрийн хөрөнгийн алдагдлын доод хязгаарыг тооцож оруулсан. Энэ тохиолдолд зорилтын функц нь эрс хотгороос гадна шугаман зааглалттай учир Нэшийн тэнцвэрийн цэг цор ганц олдохыг харуулж, хүчин зүйлүүдийн хамаарал буюу мэдрэмжийн судалгаа хийгдсэн байдаг. Ер нь тухайн хэрэглэгчийн хувьд даатгалтай байх эсэх нь эдийн засгийн хүчин зүйлээс хамааралтай гэж үзэн, нэг даатгалын компаниас нөгөөд шилжих магадлалыг тооцсон шилжилтийн матрицийг оруулах замаар олон үет загварыг томъёолон, Нэшийн тэнцвэр цэг цор ганц олдох болон мэдрэмжийн талаар үр дүнгүүдийг гарган авсан нь 2018 оны 12-р сард Applied Mathemaisics сэтгүүлд хэвлэгдсэн.

2019 он:

- Төслийн удирдагч Проф. Л.Алтангэрэл 2019 оны 6-р сарын 21-23-нд Улаанбаатар хотод болсон "The 6th International Conference on Optimization, Simulation and Control" олон улсын хурлыг Проф. Р.Энхбат, Dr. Ч.Алтаннаар, Dr. Ч.Баттушиг нарын хамт хамтран зохион байгуулсан бөгөөд уг хуралд 10 гаруй орны 50 гаруй эрдэмтэн, судлаачид илтгэлээ хэлэлцүүлсэн. Төслийн багаас уг хуралд нийт 2 илтгэл амжилттай хэлэлцүүлсэн.
- Австрийн Венийн их сургуулийн судлаач Dr. Роберт Четнек 2019 оны 11-р сарын 20-24-нд уг судалгааны төслийн хүрээнд МГТИС-д айлчлах үеэр Квази вариацийн тэнцэтгэл бишийн хувьд зааглалт нь шилжигч олонлог байх тохиолдолд алгорит боловсруулах талаар хамтарсан судалгааны семинар явуулсан бөгөөд үр дүнд нь тухайн бодлогыг бodoх Цэнгийн алгоритмыг санал болгож, нийлэлтийн баталгаа нь хийгдсэн.
- Мөн 2019 оны 10-р сард ОХУ-ын Эрхүүгийн их сургуульд болсон "Dynamical Systems, Optimal Control and Mathematical Modeling" сэдэвт олон улсын хуралд Dr. Г.Баттөр оролцож, "Theory and Methods for Generalized Nash Equilibrium Problems" сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн. Тухайлбал оптимизацийн хосмогийн онол, шийд оновчтой байх нөхцөл болон торгуулийн функцийг ашиглан Ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн бодлогыг параметрээс хамаарсан вариацийн тэнцэтгэл бишид шилжүүлэх замаар аль болох олон шийдийг олох аргыг санал болгосон судалгааны үр дүн Bulletin of Irkutsk State University. Series Mathematics сэтгүүлд хэвлэгдсэн.
- Хөрөнгийн даатгалын хувьд томъёолсон олон үет загварыг банкны салбарт хэрхэн хэрэглэх боломжтой талаар судалж, зарим үр дүнг гарган авсан. Зээлийн хүүгээрээ өрсөлддөг банкны зах зээлд төв банкнаас шаарддаг өөрийн хөрөнгийн үнэлгээний үзүүлэлтийг хангасан байхаар банкууд Нэшийн тэнцвэрт хүргэх зээлийн хүүг хэрхэн тогтоох боломжтойг үзүүлсэн. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зааглалтаар Basel-I, Basel-II-аас шаарддаг өөрийн хөрөнгийн зааглалт мөн Expected Shortfall зааглалтыг авч үзсэн. Загваруудын хувьд тэнцвэрт хүү оршин байхыг баталж, мэдрэмжийн шинжилгээг хийж сонгон авсан гурван банкны хувьд тоон туршилт явуулсан. Энэхүү үр дүнг 2019 оны 3-р сарын 27-нд явагдсан Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний хурлын сүүлийн шатаанд амжилттай шалгаран оролцож, багаараа 2-р байрыг эзэлснээс гадна энэ судалгааны ажил Optimization Methods and Software сэтгүүлийн 2021 оны дугаарт хэвлэгдсэн.

2020-2021 он:

- 2020 оны эхээр КОВИД цар тахал гарсантай холбоотойгоор төслийн санхүүжилт хойшлогдсон боловч судалгааны семинарыг тогтмол явуулж, сэтгүүлд

явуулсан ажлуудыг сайжруулах болон Нэшийн тэнцвэрийн загварын хэрэглээ болон оптимизаци, вариацийн тэнцэтгэл биштэй холбоотой судалгааг үргэлжлүүлсэн. 2021 оны эхээр Боловсрол шинжлэх ухааны яам, Шинжлэх ухаан, технологийн сан зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцсон ажлын хэсэгт төслийн явцын үр дүнгүүдийг танилцуулсны үр дүнд З дахь жилийн санхүүжилтийг олгосноор зарим төлөвлөсөн ажлуудыг үргэлжлүүлж төслийг амжилттай дуусгах боломжийг олгосон.

- Тухайлбал, 2019 онд Улаанбаатарт болсон олон улсын хурлын үеэр ярилцаж тохирсоор Францын Версалийн их сургуультай хамтран CIMPA буюу Олон улсын онолын болон хэрэглээний математикийн төвийн дэмжлэгтэйгээр "Data assimilation, optimization, and applications" сэдэвт олон улсын зуны сургалтыг 2021 оны 7-р сарын 5-наас 10-ны хооронд амжилттай зохион байгууллаа. CIMPA-аас магистр, докторын оюутнууд, судлаачдад зориулсан энэхүү зуны сургалтыг 1997 оноос хөгжиж буй орнуудад зохион байгуулж эхэлсэн бөгөөд Монголын хувьд өмнө нь 2013 онд МУИС, ШУТИС-д, 2015 онд МУИС, мөн 2017 онд ШУТИС болон Ховд их сургуультай хамтран зохион байгуулж байсан. Энэ удаагийн "Data assimilation, optimization, and applications" сэдэвт сургалтыг COVID-19 цар тахалтай холбоотойгоор МГТИС-д цахимаар болон танхимд гэсэн хосолмол хэлбэрээр зохион байгуулснаараа онцлогтой бөгөөд ШУА-ийн Математик, тоон технологийн хүрээлэн, МУИС, ШУТИС, МУБИС, МГТИС болон Франц, Итали зэрэг орнуудаас 50 гаруй хүн оролцхоор бүртгүүлж, 10 гаруй нь танхимаар оролцсон. Энэ удаагийн сургалтанд оптимизацийн үндэс, бүхэл тоон програмчлал, квази гүдгэр оптимизаци, тоглоомын онол, оптимизацийн эдийн засаг, санхүү дэх хэрэглээ, болон хар хайрцагны симуляци, тодорхойгүй нөхцөл дэх оптимизацийн үндэс зэрэг практик хэрэглээ бүхий сэдвүүдээр Версалийн их сургуулийн профессор Лоран Дюма, Версалийн их сургуулийн профессор Ц.Идэр, ШУА-ийн МТТХ-ийн секторын эрхлэгч, проф. Р.Энхбат, Перпанегийн их сургуулийн профессор Диде Осель зэрэг профессор, багш нар 2-3 удаагийн сонирхолтой лекцийг хэлэлцүүлсэн нь оролцогчид, судлаачдын хувьд судалгаанд хэрэгцээтэй суурь мэдлэгийг өгч, цаашид энэ чиглэлээр судалгаанд оролцоход дэмжлэг үзүүлсэн сургалт болсон.
- 2021 оны 10-р сард төслийн судлаач, МУИС-ийн багш Г.Баттулга "Mathematical Models in Finance and Insurance" сэдвээр Математикийн ухааны докторын зэргийг амжилттай хамгаалсан.

Энэхүү төслийн хүрээнд хэвлэгдсэн нэг сэдэвт бүтээл, судалгааны өгүүлэл болон илтгэлүүдийг жагсаавал:

Докторын диссертаци

1. Battulga, G. *Mathematical Models in Finance and Insurance*, PhD dissertation, National University of Mongolia, 2021.

Судалгааны өгүүлэл

1. Battulga, G.; Altangerel, L. ; Battur, G. *An extension of the one period model in non-life insurance markets*, Applied Mathematics 9, No.12, 1339-1350, 2018.
2. Баттулга, Г.; Алтангэрэл, Л.; Battur, Г. *Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зааглалттай банкны зээлийн хүүгийн өрсөлдөөний загвар*, Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, 2019.
3. Altangerel, L.; Battur, G. *An Exact Penalty Approach and Conjugate Duality for Generalized Nash Equilibrium Problems with Coupling and Shared Constraints*, the Bulletin of Irkutsk State University. Series Mathematics, , vol. 32, pp. 3-16, 2020.
4. Altangerel, L. *On Characterizations of Weak Sharp Minima in Optimization Problems with Applications to Variational Inequalities*, Mongolian Mathematical Journal 22, 13-19, 2020.
5. Battulga, G.; Altangerel, L. ; Battur, G. *Loan Interest Rate Nash Models with Solvency Constraints in the Banking Sector*, Optimization Methods and software. Feb. 2021 (IF – 1.431).
6. Otgochuluu, Ch.; Altangerel, L.; Khashchuluun, Ch.; Dojrsundui, G. *A game theory application in the copper market*, Resources Policy 70, March 2021 (IF – 5.634).
7. Battulga, G.; Kleinow, J.; Altangerel, L. Horsch, A. *Dividends and Compound Poisson-processes: A new Stochastic Stock Price Model*, accepted in International Journal of Theoretical and Applied Finance, 2022 (IF – 1.096).

Тавигдсан илтгэл

1. Алтангэрэл, Л. *Көвази вариацийн тэнцэтгэл бишийн хувьд динамик системтэй холбогдох зарим алгоритм*, "Хэрэглээний математик 2018" эрдэм шинжилгээний хурал, МУИС, 2018-11-17.
2. Баттулга, Г. *Stochastic Dividend Discount Model based on VAR process*, "Хэрэглээний математик 2018" эрдэм шинжилгээний хурал, МУИС, 2018-11-17.
3. Altangerel, L. *Gap functions for quasi-variational inequalities via duality*, The Vienna Workshop of Computational Optimization, Austria, December 17-19, 2018
4. Баттулга, Г. *Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зааглалттай банкны зээлийн хүүгийн өрсөлдөөний загвар*, Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний хурал 2019 оны 3-р сарын 27.
5. Altangerel, L. *Variational Inequalities and Some Applications of Nash Equilibrium Problems*, "International Conference on Optimization, Simulation and Control - 2019", June 21-23, 2019, Ulaanbaatar.
6. Battulga, G.; Kleinow, J.; Altangerel, L. *Stochastic $(n + 1)$ -period dividend discount model based on compound non homogeneous poisson process*, "International Conference on Optimization, Simulation and Control - 2019", June 21-23, 2019, Ulaanbaatar (poster)

7. Battur, G., Altangerel, L. *Theory and Methods for Generalized Nash Equilibrium Problems*, International Symposium Dynamical Systems, Optimal Control and Mathematical Modeling, October 7-11 2019, Irkutsk.

БҮЛЭГ 2

Квази вариацийн тэнцэтгэл биш ба Ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн бодлого

2.1 Квази вариацийн тэнцэтгэл бишийг бодох алгоритм

$$(QVI) \quad \langle T(x), y - x \rangle \geq 0, \forall y \in K(x)$$

нөхцлийг хангах $x \in K(x)$ векторыг олох квази-вариацийн тэнцэтгэл бишийн бодлогыг авч үзэх бөгөөд дараах нөхцлүүдийг биелдэг гэж үзье.

1. $T : \mathbb{R}^n \rightarrow \mathbb{R}^n$ нь $L \geq 0$ тогтмол бүхий Липшиц тасралтгүй:

$$\|T(x) - T(y)\| \leq L\|x - y\|, \forall x, y \in \mathbb{R}^n,$$

2. $T : \mathbb{R}^n \rightarrow \mathbb{R}^n$ нь $\rho > 0$ тогтмол бүхий хүчтэй монотон:

$$\langle x - y, T(x) - T(y) \rangle \geq \rho\|x - y\|^2, \forall x, y \in \mathbb{R}^n,$$

3. $K(x) = m(x) + K, \forall x \in \mathbb{R}^n,$

4. $K \subseteq \mathbb{R}^n$ нь хоосон, битүү, гүдгэр олонлог,

5. $m : \mathbb{R}^n \rightarrow \mathbb{R}^n$ нь $L \geq 0$ тогтмол бүхий Липшиц тасралтгүй.

Дээрх нөхцлүүд биелэх үед (QVI) бодлого нь цор ганц шийдтэй байдаг бөгөөд уг шийдийг олох дараах алгоритмыг санал болгосон.

Алгоритм:

$$\begin{cases} y^k := \text{proj}_{m(x^k)+K}(x^k - \lambda T(x^k)) \\ x^{k+1} = y^k + \lambda(T(x^k) - T(y^k)), \end{cases}$$

энд $\lambda > 0$ ба $\text{proj}_K : \mathbb{R}^n \rightarrow K$ нь $K \subseteq \mathbb{R}^n$ хоосон, битүү, гүдгэр олонлог дээрх проекцийн оператор. Тэмдэглэхэд хэрэв $m = 0$ бол энэ нь вариацийн тэнцэтгэл бишийг бодох Цэнгийн алгоритмд шилждэг. Нөгөө талаас

$$\text{proj}_{x+K}(y) = x + \text{proj}_K(y)$$

нөхцөл биелэх учир дээрх алгоритмыг

$$\begin{cases} y^k := m(x^k) + \text{proj}_K(x^k - \lambda T(x^k) - m(x^k)) \\ x^{k+1} = y^k + \lambda(T(x^k) - T(y^k)), \end{cases} \quad (2.1)$$

хэлбэрт бичиж болно. Энэ алгоритын хувьд нийлэлтийн үр дүн дараах байдлаар томъёолгодоно.

Теорем 1 (QVI) бодлогын хувьд (1) – (5) нөхцүүгүйд биелдэг ба $x^* \in K(x^*)$ уг бодлогын цор ганц шийд байг. Мөн дараах нөхцүүгүйд биелдэг гэжс үзье.

$$(i) \ lL < \rho,$$

$$(ii) \ (1 + t_1^2)l(1 + 2\lambda L + l) < 1 - (\lambda L)^2,$$

энд $t_1 := \frac{1+\lambda L+l(1+2\lambda L)+\sqrt{\Delta}}{2\lambda(\rho-lL)}$, $\Delta = (1+\lambda L+l(1+2\lambda L))+4l\lambda(1+\lambda L)(\rho-lL)$. Тэгвэл $x^0 \in \mathbb{R}^n$ анхны дөхөлтөөс эхлэн (2.1) алгоритмаар үүсгэгдэх дарааллын хувьд $q = q(l, L\rho, \lambda) \in (0, 1)$ тоо олдоод

$$\|x^{k+1} - x^*\|^2 + 2\lambda\rho\|y^k - x^*\|^2 \leq q\|x^k - x^*\|^2, \quad \forall k \in \mathbb{N}$$

нөхцөл хүчинтэй. Иймээс $\{x^k\}_{k \in \mathbb{N}}$ дараалал нь шугаман нийлэлттэй бөгөөд $\{y^k\}_{k \in \mathbb{N}}$ дараалал нь (QVI) бодлогын цор ганц шийд рүү хүчтэй нийцнэ.

2.2 Хамтын зааглалтай ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загварын зэсийн зэх зээл дэх хэрэглээ

2.2.1 Сонгодог Нэшийн тэнцвэрийн загвар ба вариацийн тэнцэтгэл биш
Нэгэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг n үйлдвэр авч үзэх бөгөөд i -р үйлдвэрийн бүтээгдэхүүний үнэ p_i нь нийт үйлдвэрлэсэн тоо хэмжээ $\sigma = \sum_{i=1}^n x_i$. Хэрэв i -р үйлдвэрийн хувьд x_i бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардлыг $h_i(x_i)$ -ээр тэмдэглэвэл, i -р үйлдвэрийн ашиг нь

$$f_i(x_1, x_2, \dots, x_n) = x_i p_i \left(\sum_{i=1}^n x_i \right) - h_i(x_i), \quad i = 1, \dots, n.$$

$X_i \subseteq \mathbb{R}$, $i = 1, \dots, n$ -ээр i -р тоглогчийн стратегийн олонлогийг тэмдэглээд гүдгэр гэж үзье. Тоглогч бурийн хувьд бусад тоглогчдын стратегиас хамааралгүйгээр ашгаа хамгийн их байлгах зорилгыг тавих бөгөөд бүх тоглогчдын хувьд нэгэн зэрэг энэ зорилгыг хангахаар олдох цэгийг Нэшийн тэнцвэрийн цэг гэдэг. Математикийн хувьд энэ бодлогыг дараах байдлаар томъёолж болно.

$$f_i(x_1^*, x_2^*, \dots, x_{i-1}^*, y_i, x_{i+1}^*, \dots, x_n^*) \leq f_i(x_1^*, x_2^*, \dots, x_n^*), \quad \forall y_i \in X_i, \quad \forall i. \quad (2.2)$$

нөхцлийг хангах $x^* = (x_1^*, x_2^*, \dots, x_n^*) \in X = X_1 \times X_2 \times \dots \times X_n$ цэгийг олох бодлогыг Нэшийн тэнцвэрийн бодлого гэдэг. Цаашид бид f_i , $i = 1, \dots, n$ ашгийн функцийг хотгор ба тасралтгүй дифференциачлагдах гэж үзнэ. Тэгвэл, тоглогч бурийн хувьд дээрх бодлого нь хотгорыг максимумчлах бөгөөд уг бодлогын шийд оновчтой байх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь

$$-\langle \nabla_{x_i} f_i(x^*), x_i - x_i^* \rangle \geq 0, \quad \forall x_i \subseteq X_i, \quad (2.3)$$

хэлбэрт бичигдэнэ, энд $\nabla_z g(z)$ нь градиент вектор ба $\langle x, y \rangle = \sum_{i=1}^n x_i y_i$, $x = (x_1, x_2, \dots, x_n)$, $y = (y_1, y_2, \dots, y_n)$ гэж тодорхойлогдох н хэмжээст 2 векторын скаляр үржвэр.

Стратегийн олонлог X_i нь гүдгэр болон хожлын функц f_i -ийн хувьд тасралтгүй ба хотгор нөхцүүд биелдэг бол Нэшийн тэнцвэрийн цэг олдоно гэдгийг Rosen 1965 онд харуулсан байдаг. $F(x)(-\nabla_{x_1} f_1(x), \dots, -\nabla_{x_n} f_n(x))$ гэсэн тэмдэглэгээг оруулах замаар Нэшийн тэнцвэрийн бодлогыг Вариацын тэнцэтгэл биш гэж нэрлэгдэх

$$\langle F(x^*), x - x^* \rangle \geq 0, \quad \forall x \in X \quad (2.4)$$

нөхцлийг хангах x^* цэгийг олох эквивалент бодлогод шилжүүлдэг.

2.2.2 Хамтын зааглалттай ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загвар

Ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загвар (ЕНТЗ) нь Нэшийн тэнцвэрийн бодлогын өргөтгөл бөгөөд тоглогч бүрийн стратегийн олонлог нь бусад тоглогчдынхоо стратегиас хамаарна гэж үздэг. Энэ загварыг анх эдийн засагт Дебрю "Сошиал тэнцвэр" гэсэн нэрээр анх оруулсан гэж үздэг. Энэ судалгааны чиглэл нь сүүлийн жилүүдэд эрчимтэй судлагдаж байгаа бөгөөд Факкиней, Канцов нар 2010 онд судалгааны ажлуудын тоймыг хэвлүүлсэн. ЕНТЗ-ийн томъёоллыг авч үзье. Бид N тоглогчтой хамтач бус тоглоом авч үзье. $x_k \in \mathbb{R}^{n_k}$, $n_k \in \mathbb{N}$ нь k -р тоглогчийн стратеги ба $x := (x_1, x_2, \dots, x_N) \in \mathbb{R}^n$, $n := \sum_{k=1}^N n_k$ ба x_{-k} -ээр k -р тоглогчоос ялгаатай бусад тоглогчдын стратегийг тэмдэглэе. $\theta_k : \mathbb{R}^n \rightarrow \mathbb{R}$, $k = 1, \dots, N$ нь k -р тоглогчийн зорилгын функц ба бэхлэгдсэн x_{-k} бүрийн хувьд $C_k(x_{-k})$ олонлог нь k -р тоглогчийн хувьд бусад тоглогчдын x_{-k} стратегиас хамаарсан стратегийн олонлог байна. Тэгвэл ЕНТЗ нь $k = 1, \dots, N$ тоглогч бүрийн хувьд

$$\theta_i(x_1^*, x_2^*, \dots, x_{k-1}^*, y_k, x_{k+1}^*, \dots, x_n^*) \geq \theta_i(x_1^*, x_2^*, \dots, x_n^*), \quad \forall y_k \in C_k(x_{-k}), \quad \forall k, \quad (2.5)$$

нөхцлийг хангахаар $x^* = (x_1^*, x_2^*, \dots, x_n^*) \in X = X_1 \times X_2 \times \dots \times X_n$ векторыг олох бодлого юм. Хэрэв $C_k(x_{-k})$ олонлог нь

$$C_k(x_{-k}) = \{x_k \in X_k \mid g(x) \leq 0\}$$

хэлбэртэй өгөгдсөн бол хамтын зааглалттай бодлого гэж нэрлэдэг.

2.2.3 Зэсийн зах зээл дэх хэрэглээ ба вариацийн тэнцэтгэл бишийн томъёолол

Судалгааны хүрээнд тэг биш нийлбэртэй, N тоглогчтой, үл эвсэлдэх тоглоомын бодлогыг зэс экспортлогч улс орнуудын хувьд томъёолсон. Загварт БНХАУ-ын зэсийн зах зээлд нийлүүлэгч улсууд дахь зэсийн баяжмал экспортлогч уурхайнуудыг тоглогч агентаар авсан. Энэ судалгаа нь Трубигийн нүүрсний зах зээлд хэрэглэсэн Нэшийн тэнцвэрийн загварт үндэслэсэн бөгөөд Хятадын зах зээлийн эрэлттэй холбоотойгоор хамтын зааглалтыг нэмж тооцсоноор уг загвар нь Ерөнхийлсэн Нэшийн загварт шилжих болно. Ингэснээр эдийн засгийн судалгаанд ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн загварын нэгэн сонирхолтой хэрэглээг харуулсан. Хятадын зах зээлд Чили, Перу, Австрали, Монгол зэрэг орнууд зэс нийлүүлдэг байг. Өөрөөр хэлбэл, дээрх 4 улсын тоглогчтой ерөнхийлсэн Нэшийн тэнцвэрийн бодлогыг авч үзье. Тоглогч бүрийн шийдвэр гаргах хувьсагчид бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт ба эдгээр стратегиудаа зэрэг сонгоно гэж үзье. Тухайн зах зээлд тогтсон үнээр бүтээгдэхүүнээ борлуулж зардлаа тооцсоноор цэвэр ашгaa хамгийн их байлгах юм. Тэгвэл k -р тоглогчийн бодлого дараах хэлбэртэй байна. ($k = 1, \dots, 4$).

$$(Z_k) \quad \begin{aligned} & \max_{(x_{ki}, y_{ki})} \sum_{i=1}^{|M_k|} [x_{ki} P_k - C_{ki}^{var}(x_{ki}) - c_{ki}^{inv} y_{ki}] \\ & X_k = \{(x_{ki}, y_{ki}) : P_k = (a_k - b_k Q), \\ & x_{ki} - y_{ki} \leq cap_{ki}^0, \\ & y_{ki} \leq y_{ki}^{max}, \\ & Q = \sum_{k=1}^N x_k, \quad x_k = \sum_{i=1}^{|M_k|} x_{ki}, \\ & \alpha_1 x_1 + \alpha_2 x_2 + \alpha_3 x_3 + \alpha_4 x_4 \leq Total, \\ & x_{ki}, y_{ki} \geq 0, \quad i = 1, \dots, |M_k|\}. \end{aligned}$$

Энд

M_k	k -р улсын зэсийн баяжмалын үйлдвэрүүдийн олонлог
$C_{ki}^{var}(x_{ki}) = (\tau_{ki} + v_{ki})x_{ki}$	Хувьсах зардал, (үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн)
$c_{ki}^{inv} y_{ki}$	хөрөнгө оруулалтын зардал
cap_{ki}^0	үйлдвэрлэлийн суурь хүчин чадал
y_{ki}^{max}	хөрөнгө оруулалтын дээд зааг
$\alpha_i, i = 1, 2, 3, 4$	i -р улсын Хятадын зах зээлд эзэлж буй хувь
$Total$	Хятадын импортын нийт хэмжээ (Total ≤ 1)

(VI) бодлогын хувьд улс бүрээр градиент векторыг тооцоолж гаргавал:
Чилийн зэсийн баяжмал экспортлогч 4 баяжуулах үйлдвэрийн хувьд::

$$\nabla f_1 = \left(\begin{array}{c} a_k - b_k Q - \tau_{1i} - v_{1i} + \sum_{i=1}^4 x_{1i}(-b_k) \\ -c_{1i} \end{array} \right)_{i=1}^4,$$

Перугийн 3 үйлдвэрийн хувьд:

$$\nabla f_2 = \left(\begin{array}{c} a_k - b_k Q - \tau_{2i} - v_{2i} + \sum_{i=1}^3 x_{2i}(-b_k) \\ -c_{2i} \end{array} \right)_{i=1}^3,$$

Австралийн 2 үйлдвэрийн хувьд:

$$\nabla f_3 = \left(\begin{array}{c} a_k - b_k Q - \tau_{3i} - v_{3i} + \sum_{i=1}^2 x_{3i}(-b_k) \\ -c_{3i} \end{array} \right)_{i=1}^2,$$

Монгол Улсын 2 үйлдвэрийн хувьд:

$$\nabla f_4 = \left(\begin{array}{c} a_k - b_k Q - \tau_{4i} - v_{4i} + \sum_{i=1}^2 x_{4i}(-b_k) \\ -c_{4i} \end{array} \right)_{i=1}^2.$$

гэдгийг тооцон дараах хувьсагч оруулъя::

$$\begin{aligned} (x_1, \dots, x_8) : &= (x_{1i}, y_{1i}), \quad i = 1, \dots, 4, \\ (x_9, \dots, x_{14}) : &= (x_{2i}, y_{2i}), \quad i = 1, \dots, 3, \\ (x_{15}, \dots, x_{18}) : &= (x_{3i}, y_{3i}), \quad i = 1, \dots, 2, \\ (x_{19}, \dots, x_{22}) : &= (x_{4i}, y_{4i}), \quad i = 1, \dots, 2. \end{aligned}$$

Хүснэгт 2.1: Оролтын хувьсагчид

Country	Mines	Export	Investment
CHL	Escondida	x_{11}	y_{11}
	Collahuasi	x_{12}	y_{12}
	EI Teniente	y_{13}	y_{13}
	Los Pelambres	x_{14}	y_{14}
PER	Property	x_{21}	y_{21}
	Antamina	x_{22}	y_{22}
	Las Bambas	x_{23}	y_{23}
AUS	Prominent Hill	x_{31}	y_{31}
	Olympic Dam	x_{32}	y_{32}
MNG	Erdenet	x_{41}	y_{41}
	Oyu Tolgoi	x_{42}	y_{42}
IDN	Grasberg	x_{51}	y_{51}

БҮЛЭГ 3

Төлбөрийн чадварын зааглалттай даатгалын хураамжийн загвар

3.1 Нэг үет даатгалын загвар

I даатгагчтай n даатгуулагчтай даатгалын зах зээл авч үзье. Даатгуулагчид тухайн даатгалын компанидаа үргэлжлүүлэн даатгуулах эсвэл өрсөлдөгч даатгалын компани руу шилжиж даатгуулахаа өөрсдөө шийддэг байг.

Бид $(x_1, \dots, x_I) \in \mathbb{R}^I$ - ээр үнийн векторыг тэмдэглэе, энд x_j нь j -дүгээр даатгуулагчийн хураамж. Бүх даатгалын компаниуд хураамжаа тогтоосны дараа даатгуулагчид өөрсдийн даатгуулсан компанидаа үргэлжлүүлэн даатгуулах эсвэл өөр компани сонгено. Үүний дараа даатгалын компаниуд тухайн даатгалын жилд гарсан нөхөн олговрыг өөрийн даатгалын багцынхаа хүрээнд төлж барагдуулна.

Тухайн даатгалын жилд гарсан i -дүгээр даатгуулагчаас учрах боломжит хохиролыг Y_i -ээр тэмдэглэн Y_i , $i \in \{1, \dots, n\}$ -үүдийг үл хамаарах нэгэн ижил тархалттай гэж үзье.

Энэ тохиолдолд j -дүгээр даатгагчид учрах нийт нэхэмжлэлийн хэмжээ $S_j(x) = \sum_{i=1}^{N_j(x)} Y_i$, энд $N_j(x)$ нь x үнийн вектор өгөгдсөн үеийн j -дүгээр даатгалын компанийн багц буюу даатгуулагчдын тоо.

n_j нь j -дүгээр даатгалын компанийн хугацааны эхэн дэх анхдагч даатгалын багц байг $\Theta/x \sum_{j=1}^I n_j = n$. Энэ тохиолдолд j -дүгээр даатгалын зорилгын (ашгийн) функц дараах хэлбэрээр илэрхийлэгдэнэ:

$$O_j(x) = \frac{n_j}{n} \left(1 - \beta_j \left(\frac{x_j}{m_j(x)} - 1 \right) \right) (x_j - \pi_j), \quad (3.1)$$

энд π_j нь j -дүгээр даатгуулагчийн хугарлын цэгийн хураамж ба $m_j(x)$ нь бусад даатгалын компаниудын дундаж хураамж

$$m_j(x) = \frac{1}{I-1} \sum_{k \neq j} x_k.$$

Даатгалын компаниуд дээрх зорилгын функцийг максимумчилахаас гадна бодлого боловсруулагчидын тогтоосон төлбөрийн чадварын зааглалтыг хангаж байх ёстой. j -дүгээр даатгалын компанийд харгалзах төлбөрийн чадвар ойролцоогоор дараах томъёо-гоор өгөгднө:

$$SCR_q \approx k_q \sigma(Y) \sqrt{n_j}.$$

Энэ тохиолдолд төлбөрийн чадварын функц доорх байдлаар тодорхойлогдоно:

$$g_j(x_j) = \frac{K_j + n_j(x_j - \pi_j)(1 - e_j)}{k_q \sigma(Y) \sqrt{n_j}} \geq 1,$$

энд e_j нь бохир хураамжид харгалзах зардлын хувь. Амьдралын бус даатгалын зах зээл дэх нэг-үет Нэшийн тэнцвэрийн загвар дараах байдлаар тавигдана:

$$\max_{x_j \in X_j} O_j(x), \quad j = 1, \dots, I,$$

энд

$$\begin{aligned} X_j &:= \{x_j \in [x, \bar{x}] \mid g_j(x_j) \geq 0\} \\ &= \{x_j \in [x, \bar{x}] \mid K_j + n_j(x_j - \pi_j)(1 - e_j) \geq k_q \sigma(Y) \sqrt{n}\}, \end{aligned} \quad (3.2)$$

ба \underline{x} , \bar{x} ҮҮД нь хамгийн бага ба хамгийн их хураамжууд.

3.2 Нэг үет загварын өргөтгөл

t нь үеийн тоо байг. Нэг үетэй загварыг t -үетэй болгож өргөтгөхийн тулд даатгуулагчид тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн шийдвэрээ гаргана гэж үзье. Өөрөөр хэлбэл, эдийн засаг сайжирвал даатгуулагчидийн даатгуулах сонирхол нэмэгдээ нэ. $z(k) \in \mathbb{R}^q$ нь k -дугаар үе дэх эдийн засгийн хүчин зүйл, $\gamma_{ij}(k) \in \mathbb{R}^q$ нь даатгуулагч i -ээс j -дүгээр даатгуулагч руу шилжихэд харгалзах эдийн засгийн параметрийн вектор ба даатгуулагчид даатгагч руу шилжих шилжилтийн магадлалын матриц доорх байдлаар тодорхойлогдоно гэж үзье:

$$P(k) = \begin{pmatrix} p_{1,1}(k) & p_{1,2}(k) & \cdots & p_{1,I}(k) & p_{1,I+1}(k) \\ p_{2,1}(k) & p_{2,2}(k) & \cdots & p_{2,I}(k) & p_{2,I+1}(k) \\ \vdots & \vdots & \ddots & \vdots & \vdots \\ p_{I,1}(k) & p_{I,2}(k) & \cdots & p_{I,I}(k) & p_{I,I+1}(k) \\ p_{I+1,1}(k) & p_{I+1,2}(k) & \cdots & p_{I+1,I}(k) & p_{I+1,I+1}(k) \end{pmatrix},$$

энд $p_{i,j}(k)$ нь харилцагч k -дугаар үед i -дүгээр даатгагчаас j -дүгээр даатгагч руу шилжих магадлал. $(I+1)$ -дугаар багана нь идэвхгүй төлөв буюу даатгуулаагүй харилцагчидад харгалзана. Шилжилтийн магадлал дараах байдлаар загварчлагдана:

$$p_{i,j}(k) = \begin{cases} \frac{1}{1 + \sum_{l=1}^I \exp(\langle \gamma_{il}(k), z(k) \rangle)} & \text{if } j = I+1 \\ \frac{\exp(\langle \gamma_{ij}(k), z(k) \rangle)}{1 + \sum_{l=1}^I \exp(\langle \gamma_{il}(k), z(k) \rangle)} & \text{if } j \neq I+1, \end{cases}$$

энд $\langle \cdot, \cdot \rangle$ скаляр үржвэрийн оператор. Хэрэв эдийн засаг k -дугаар үед муудвал даатгуулагчид даатгуулах сонирхолгүй болох ба ингэснээр $p_{i,j}(k)$, $j = 1, \dots, I$ магадлалууд бууран $p_{i,I+1}$ магадлал өснө.

k -дугаар үед харгалзах j -дүгээр даатгалын компанийн багцын хэмжээ $N_j(k)$ нь үргэлжлүүлэн даатгуулж буй болон бусад даатгалын компаниудаас шилжин ирсэн даатгуулагчидадаас бүрдэнэ. Иймд

$$\begin{aligned} N_j(k) &= N_j(k-1)p_{j,j}(k) + \sum_{i=1, i \neq j}^{I+1} N_i(k-1)p_{i,j}(k) \\ &= \sum_{i=1}^{I+1} N_i(k-1)p_{i,j}(k), \end{aligned}$$

энд $N_j(0) = n_j$. r_f нь эрсдэлгүй хүү ба $v = \frac{1}{1+r_f}$ нь хямдруулалтын хүчин зүйл байг. Дутангийн ажилд (2013) үндэслэвэл, j -дүгээр даатгалын компани дараах зорилгын (ашгийн) функцийг максимумчлахаар зорих болно:

$$O_m^j(x) = \sum_{k=1}^m \frac{v^k N_j(k)}{n} \left(1 - \beta_j(k) \left(\frac{x_j^k}{m_j(x^k)} - 1 \right) \right) (x_j^k - \pi_j(k)), \quad (3.3)$$

энд $x = (x_1^T, \dots, x_I^T)^T$, $x_j = (x_j^1, \dots, x_j^m)^T$, $j = 1, \dots, I$, ба $m_j(x^k) = \frac{1}{I-1} \sum_{i \neq j} x_i^k$. j -дүгээр даатгуулагчид харгалзах төлбөрийн чадварын зааглалт дараах байдлаар томъёологдоно:

$$g_\ell^j(x_j) = \frac{K_j + \sum_{k=1}^{\ell} v^k N_j(k)(x_j^k - \pi_j(k))(1 - e_j(k))}{k_q \sigma(Y) \sqrt{\sum_{k=1}^{\ell} v^k N_j(k)}} - 1, \quad \text{for } \ell = 1, 2, \dots, m.$$

Иймд j , $j \in \{1, \dots, I\}$ дүгээр тоглогч бүрийн стратегийн олонлог

$$\begin{aligned} X_m^j : &= \{x_j \in [\underline{x}, \bar{x}]^m \mid g_\ell^j(x_j) \geq 0, \ell = 1, \dots, m\} \\ &= \left\{ x_j \in [\underline{x}, \bar{x}]^m \mid K_j + \sum_{k=1}^{\ell} v^k N_j(k)(x_j^k - \pi_j(k))(1 - e_j(k)) \right. \\ &\quad \left. \geq k_q \sigma(Y) \sqrt{\sum_{k=1}^{\ell} v^k N_j(k)}, \ell = 1, \dots, m \right\} \end{aligned} \quad (3.4)$$

байна. m -үетэй загвард харгалзах [?]-тэй төстэй үр дүнгүүдийг өгье.

Өгүүлбэр 1 (3.3) зорилгын функцууд (3.4) төлбөрийн чадварын зааглалтуудтай I тоглогчтой m -үетэй даатгалин тоглоом нь цог ганц Нэшийн тэнцвэрийн цэгтэй байна.

Өгүүлбэр 2 x^* нь I тоглогч m -үетэй даатгалин тоглоомын тэнцвэрт хураамжс байг. Тэсвэл

1. хэрэв бүх төлбөрийн чадварын зааглалтууд идэвхитэй эсвэл идэвхигүй бол j -дүгээр тоглогч болон k -дугаар үе бүрийн хувьд харгалзах $x_j^{k*} \in [\underline{x}, \bar{x}]$ тэнцвэрт хураамжс параметрүүдээс дараах байдлаар хамаарна:

- (i) хугарлын цэгийн хураамж $\pi_j(k)$, төлбөрийн чадварын коэффициент k_q , хохирлын хэлбэлзэл $\sigma(Y)$, зардлын хувь $e_j(k)$, болон $k \geq 2$ хувьд эрсдэлгүй хүү r_f -гүйдээс эерэгээр
- (ii) мэдрэмжийн параметр $\beta_j(k)$, $k = 1$ үед капитал K_j болон $k \geq 2$ үед багцын хэмжээ $N_j(\ell)$, $\ell = 1, \dots, k$ -гүйдээс сөрөг хамаарна.

2. хэрэв бүх зааглалтын функцууд идэвхигүй бол тэнцвэрт хураамжс нь

$$M_\beta x^* = v,$$

шугаман тэгшигтгэлийн системийн шийд байна, энд

$$M_\beta = \begin{pmatrix} A_1 & 0 & 0 & \cdots & 0 \\ 0 & A_2 & 0 & \cdots & 0 \\ \vdots & \vdots & \vdots & \ddots & \vdots \\ 0 & 0 & 0 & \cdots & A_m \end{pmatrix},$$

$$v = (\beta_1(1)\pi_1(1), \dots, \beta_I(1)\pi_I(1), \dots, \beta_1(m)\pi_1(m), \dots, \beta_I(m)\pi_I(m))^T,$$

ба

$$A_k = \begin{pmatrix} 2\beta_1(k) & -\frac{1+\beta_1(k)}{I-1} & \cdots & -\frac{1+\beta_1(k)}{I-1} \\ -\frac{1+\beta_2(k)}{I-1} & 2\beta_2(k) & \cdots & -\frac{1+\beta_2(k)}{I-1} \\ \vdots & \vdots & \ddots & \vdots \\ -\frac{1+\beta_I(k)}{I-1} & -\frac{1+\beta_I(k)}{I-1} & \cdots & 2\beta_I(k) \end{pmatrix}, \quad k = 1, \dots, m.$$

Хүснэгт 3.1: Scenario 1

Player	I			II			III		
Period	1	2	3	1	2	3	1	2	3
$E(Y)$	1								
k_q	3								
r_f	0.05								
$\sigma(Y)$	10.488								
K_j	2807.190			2367.231			2006.917		
$\beta_j(k)$	3.0	3.5	3.0	3.8	3.9	3.8	4.6	5.6	4.6
$e_j(k)$	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15
$\pi_j(k)$	1.10	1.10	1.10	1.117	1.117	1.117	1.083	1.083	1.083
$N_j(k)$	4500	4500	4500	3200	3200	3200	2300	2300	2300
equil/prem	1.544	1.472	1.544	1.511	1.463	1.510	1.471	1.406	1.471

Хүснэгт 3.2: Scenario 2

Player	I			II			III		
Period	1	2	3	1	2	3	1	2	3
$E(Y)$	1								
k_q	3								
r_f	0.05								
$\sigma(Y)$	10.488								
K_j	2807.190			2367.231			2006.917		
$\beta_j(k)$	3.0	3.0	3.0	3.8	3.8	3.8	4.6	4.6	4.6
$e_j(k)$	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15	0.15
$\pi_j(k)$	1.15	1.10	1.10	1.117	1.100	1.117	1.083	1.083	1.183
$N_j(k)$	4500	4500	4500	3200	3200	3200	2300	2300	2300
equil/prem	1.580	1.538	1.579	1.527	1.499	1.544	1.487	1.466	1.542

3.3 Тоон туршилт

Энэ хэсэгт Өгүүлбэр 2-д гарсан үр дүнг тоон туршилтаар баталж харуулъя. Бид гурван-үетэй гурван тоглогчтой тоглоом авч үзсэн.

a) *Scenario 1:*

Хүснэгт 3.1-д 2-дугаар үед бүх тоглогчдын мэдрэмжийн параметр өсөх үеийн үр дүнг харуулав. Энэ тохиолдолд тэнцвэрт хураамж зөвхөн 2-дугаар үед л өөрчлөгдсөн.

b) *Scenario 2:*

Энэ тохиолдолд 1-дүгээр үе дэх 1-дүгээр тоглогч болон 3-дугаар үе дэх 3-дугаар тоглогчийн хугарлын цэгийн хураамжийг өсгөж 2-дугаар үе дэх 2-дугаар тоглогчийн хугарлын цэгийн хураамжийг бууруулсан үеийн үр дүнг харуулав. Энэ тохиолдолд, 1 болон 3-дугаар тоглогчийн 1 болон 3-дугаар үеийн тэнцвэрт хураамж өсөн 2 дугаар тоглогчийн 2 дугаар үеийн тэнцвэрт хураамж буурсан. Бусад параметрүүдэд харгалзах мэдрэмжийн шинжилгээг диссертацаас харж болно.

БҮЛЭГ 4

Төлбөрийн чадварын зааглалттай банкны зээлийн хүүгийн загварууд

4.1 Төлбөрийн чадварын зааглалттай банкны загвар

Энэ хэсэгт бид төлбөрийн чадварын зааглалттай зээлийн хүүгийн Нэшийн тоглоом авч үзэх болно. Одоо загварынхаа талаар дэлгэрүүлж авч үзье. Зах зээлд зээлийн хүүгээрээ өрсөлддөг N тооны банкууд үйл ажиллагаа явуулдаг ба зээлдэгч бүр R тооны зээлийн зэрэглэлийн аль нэгэнд харьяалагддаг байг. i -дүгээр зээлийн зэрэглэлтэй зээлийн хувьд түүний дефолт болох магадлал эрсдэлийн хүчин зүйл (эдийн засгийн хүчин зүйл) Ψ -ийн нөхцөлд $p_i(\Psi)$ байг. $p_i(\cdot)$ нь аргументаараа эрс өсдөг функц гэж үзье. Энэ тохиолдолд эрсдэлийн хүчин зүйл өсвөл (эдийн засаг муудвал) зээлдэгчийн дефолт болох магадлал өсөх бол эрсдэлийн хүчин зүйл буурвал (эдийн засаг сайжирвал) зээлдэгчийн дефолт болох магадлал буурна. Мөн i -дүгээр зэрэглэлтэй зээлийн хувьд дефолт болсон нөхцөлд тухайн зээлээс учрах алдагдал (loss given default-LGD) Δ_i байг. $\Delta_{i\text{-г}} (0, 1]$ -д утгатай гэж үзнэ. Мөн n -дүгээр банкны хувьд i -дүгээр зэрэглэлтэй зээлийн нийт үлдэгдэл $L_{i,n}$ байсан ба n -дүгээр банкны хувьд $x_{i,n}$ нь i -дүгээр зэрэглэлтэй зээлийн хүү тус тус байг. Дутанг нарын болон Баттулга нарын [?] судалгааны ажлууд дээр үндэслэвэл n -дүгээр банк дараах хэлбэртэйгээр тодорхойлогдох татварын өмнөх цэвэр ашгийг максимумчилна:

$$O_n(x) = \sum_{i=1}^R L_{i,n} \left(1 - \beta_{i,n}^L \left(\frac{x_{i,n}}{m(x_{i,n})} - 1 \right) \right) (x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)), \quad (4.1)$$

Энд i -дүгээр зээлийн зэрэглэлтэй n -дүгээр банкны хувьд $\beta_{i,n}^L > 0$ нь хүүгийн мэдрэмжийн параметр, $\pi_{i,n}$ нь хугарлын цэгийн хүү, e_n нь зардлын хувь, $x = (x_1^T, \dots, x_N^T)^T$ нь бүх тоглогчдийн зээлийн хүү, $x_n = (x_{1,n}, \dots, x_{R,n})^T$ нь n -дүгээр банкны зээлийн зэрэглэлүүдтэй холбоотой хүүнүүд ба $m(z_{i,n}) = \frac{1}{N-1} \sum_{k \neq n} z_{i,k}$ нь бусад тоглогчдийн санал болгож буй хүүнүүдийн дундаж.

Төлбөрийн чадварын зааглалт нь эдийн засгийн хүндрэлийн үед хадгаламж эзэмшигчдийг хамгаалах зорилгоор тодорхой хэмжээний капиталыг банк хангаж байх шаардлага юм. Иймд (4.1) зорилгын функцийг максимумчилхаас гадна банк бодлого боловсруулагчдын тогтоосон төлбөрийн чадварын зааглалтыг хангах ёстой. Энэ ажлын хүрээнд Basel I, Basel II болон ES гэсэн гурван төрлийн төлбөрийн чадварын зааглалтуудыг авч үзэх ба эдгээр нь манай загварын гол онцлог юм.

n -дүгээр банкны хувьд i -дүгээр зээлийн рейтингтэй нийт $m_{i,n}$ тооны зээлдэгч байгаа гэж үзье. Уг зээлүүдийн хувьд k -дугаар зээлдэгч дефолт болвол 1 дефолт болоогүй бол 0-ийг авах дефолт индикаторийн санамсаргүй хэмжигдэхүүн $Y_{i,k,n}$ болон түүний зээлийн үлдэгдлийг илэрхийлэх $e_{i,k,n}$ өгөгдсөн байг. Энэ тохиолдолд k -дугаар зээлдэгч дефолт болох магадлал $\mathbb{P}(Y_{i,k,n} = 1 | \Psi) = p_i(\Psi)$, $k = 1, \dots, m_{i,n}$ болох ба зээлдэгч бүрийн зээлийн үлдэгдлүүдийн нийлбэр нийт зээлийн үлдэгдэл байна: $\sum_{k=1}^{m_{i,n}} e_{i,k,n} = L_{i,n}$. Иймд n -дүгээр

банкны зээлийн багцаас учрах санамсаргүй алдагдлын хэмжээ дараах хэлбэртэйгээр илэрхийлэгдэнэ:

$$Q_n := \sum_{i=1}^R \sum_{k=1}^{m_{i,n}} e_{i,k,n} \Delta_i Y_{i,k,n}.$$

Харин эрсдэлийн хүчин зүйл Ψ -ийн нөхцөлд дундаж алдагдлын хэмжээ

$$\mathbb{E}(Q_n|\Psi) := \sum_{i=1}^R \sum_{k=1}^{m_{i,n}} e_{i,k,n} \Delta_i \mathbb{E}(Y_{i,k,n}|\Psi) = \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i p_i(\Psi)$$

байна. Бид [?] (мөн [?]-г хар) ажил дээр үндэслэвэл (энэхүү ажлын хүрээндэх регуляр нөхцлүүд биелнэ гэж үзнэ), хэрэв зээлдэгчдийн тоо хүрэлцээтэй их бол алдагдлын санамсаргүй хэмжигдэхүүн Q_n -ийн α эрэмбийн квантилийн хувьд дараах ойролцоо томъёо биелнэ.

$$q_\alpha(Q_n) \approx \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i p_i(q_\alpha(\Psi)),$$

энд $q_\alpha(X) = \inf\{x \in \mathbb{R} : \mathbb{P}(X \leq x) \geq \alpha\}$ нь X санамсаргүй хэмжигдэхүүний α эрэмбийн квантиль ([?]-г хар). [?]-д зээлийн багцын алдагдлын харьцааны хувьд дээрх ойролцоо томъёотой төстэй томъёо гаргасан байдаг. [?] ажлыг зээлийн эрсдэлийн хувьд Basel II зөвлөмжийг боловсруулахад ашиглагдсан нөлөө бүхий ажил гэж үздэг. Энэ тохиолдолд n -дүгээр банкны хувьд Ψ нөхцөл дэх Basel II өөрийн хөрөнгийн хүрэлцээний зааглалт доорх хэлбэртэйгээр тодорхойлогдоно:

$$g_n^1(x_n) = K_n + \sum_{i=1}^R L_{i,n} (x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) - \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i p_i(q_\alpha(\Psi)).$$

Basel I нь анх 1988 онд банкуудын зээлийн эрсдэлийг багасгах зорилгоор зээлүүдийг ангилалаас нь хамааруулан үлдэгдлээс нь тодорхой хувь тооцон нийт дүнгийн хэмжээ нь банкны капиталын 8%-аас их байхыг шаардсан хамгийн анхны зээлийн эрсдэлийн зохицуулалт байсан. FSI Survey судалгаанд харуулснаар Монгол улсыг оролцуулаад Basel II-ийн хэрэгжилтэнд идэвхгүй зарим улсууд байсан. Энэ шалтгаанаар Basel I зааглалтыг өөрсдийн судалгаанд оруулсан. Ψ нөхцөл дэх Basel I төлбөрийн чадварын зааглалт дараах байдлаар тодорхойлогдоно:

$$g_n^2(x_n) = K_n + \sum_{i=1}^R L_{i,n} (x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) - c \sum_{i=1}^R L_{i,n} w_i,$$

энд c нь эрсдэлээр жигнэсэн активын хувь ба w_i нь i -дүгээр зээлийн рейтингтэй зээлийн хувьд эрсдэлийн жин.

Artzner нар санхүүгийн эрсдэлийн удирдлагад анх уялдсан эрсдэлийн хэмжээсийг (coherent risk measure) оруулж ирсэн. Алдагдлын санамсаргүй хэмжигдэхүүний квантилын тодорхойлолтоос VaR нь хувиргалтаар инвариант, эерэг нэгэн төрлийн, монотон болохыг харуулж болдог. Харин субаддитив чанар VaR-ын хувьд ерөнхий тохиодолд биелдэггүй. Гэвч Acerbi & Tasche нарын танилцуулсан Expected Shortfall нь уялдаатай эрсдэлийн хэмжээс байж чаддаг. $E(|X|) < \infty$ нөхцлийг хангасан X санамсаргүй хэмжигдэхүүний хувьд $\alpha \in (0, 1)$ итгэх түвшинд харгалзах Expected Shortfall дараах байдлаар тодорхойлогдоно:

$$\text{ES}_\alpha(X) = \frac{1}{1-\alpha} \left\{ \mathbb{E}[XI_{\{X \geq q_\alpha(X)\}}] + q_\alpha(X)[1 - \alpha - \mathbb{P}(X \geq q_\alpha(X))] \right\},$$

энд I_A нь A үзэгдлийн индикатор функц.

Хэрэв бид зээлийн алдагдлын багцын квантилыг ойролцоогоор илэрхийлэхийн тулд expected shortfall-ийн

$$\text{ES}_\alpha(X) = \frac{1}{1-\alpha} \int_\alpha^1 q_u(X) du$$

томъёог ашиглавал n -дүгээр банкны зээлийн багцын $\alpha \in (0, 1)$ итгэх түвшинд харгалзах Expected Shortfall-ын хувьд дараах ойролцоо томъёо биелнэ:

$$\text{ES}_\alpha(Q_n) \approx \frac{1}{1-\alpha} \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i \int_\alpha^1 p_i [q_u(\Psi)] du.$$

энд Лемма 2-оос

$$h_i(\alpha) := \frac{1}{1-\alpha} \int_\alpha^1 p_i [q_u(\Psi)] du, \quad i = 1, \dots, R$$

ууд тасралтгүй өсөх функц болох нь мөрдөнө. Иймд n -дүгээр банкны хувьд Ψ нөхцөл дэх ES төлбөрийн чадварын зааглалт:

$$g_n^3(x_n) = K_n + \sum_{i=1}^R L_{i,n} (x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) - \frac{1}{1-\alpha} \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i \int_\alpha^1 p_i [q_u(\Psi)] du.$$

Иймд n -дүгээр тоглогчийн $n \in \{1, \dots, N\}$ стратегийн олонлог Basel II, Basel I, and ES зааглалтын тохиолдлуудад дараахаар өгөгднө:

Basel II:

$$\begin{aligned} X_n^1 &= \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid g_n^1(x_n) \geq 0 \right\} \\ &= \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid K_n + \sum_{i=1}^R L_{i,n} (x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) \geq 0 \right\} \\ &\geq \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i p_i(q_\alpha(\Psi)) \geq 0 \right\}, \end{aligned} \quad (4.2)$$

Basel I:

$$\begin{aligned} X_n^2 &= \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid g_n^2(x_n) \geq 0 \right\} \\ &= \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid K_n + \sum_{i=1}^R L_{i,n} (x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) \geq 0 \right\} \\ &\geq \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid c \sum_{i=1}^R L_{i,n} w_i \geq 0 \right\}, \end{aligned} \quad (4.3)$$

ES:

$$\begin{aligned} X_n^3 &= \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid g_n^3(x_n) \geq 0 \right\} \\ &= \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid K_n + \sum_{i=1}^R L_{i,n} (x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) \geq 0 \right\} \\ &\geq \left\{ x_n \in \prod_{i=1}^R [\underline{x}_i, \bar{x}_i] \mid \frac{1}{1-\alpha} \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i \int_\alpha^1 p_i [q_u(\Psi)] du \geq 0 \right\}, \end{aligned} \quad (4.4)$$

энд $i = 1, \dots, R$ -ийн хувьд $\underline{x}_i, \bar{x}_i$ нь i -дүгээр зээлийн зэрэглэлтэй зээлийн хүүгийн хамгийн бага, хамгийн их утгууд. Энэхүү хамгийн бага, хамгийн их зээлийн хүүнүүдийг бодлого боловсруулагчид тогтоох (зарим улсууд зээлийн хүүгийн тааз тогтоосон байдаг) боломжтой. (4.2) – (4.4) тэгшигтгэлүүдийн хувьд $\sum_{i=1}^R L_{i,n}(x_{i,n} - \pi_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi))$ нь n -дүгээр банкны капиталын өөрчлөлтийг илэрхийлэх ба n -дүгээр банк өөрийн зээлийн олгох үйл ажиллагааныхаа дараа төлбөрийн чадвартай байх баталгааг өгнө. ES зааглалттай банкны салбар дахь загварыг тодорхойлохын тулд бидэнд дараах Леммүүдийн үр дүн хэрэгтэй.

Лемма 1 Ψ нь бодит утгатай санамсаргүй хэмжсигдэхүүн, $p : \mathbb{R} \rightarrow [0, 1]$ эрс өсдөг фүнки, $f_\Psi(\alpha) := (1 - \alpha)^{-1} \{ \mathbb{E}[p(\Psi) I_{\{\Psi \geq q_\alpha(\Psi)\}}] + p[q_\alpha(\Psi)] (1 - \alpha - \mathbb{P}(\Psi \geq q_\alpha(\Psi))) \}$ байг. Тэгвэл дараах үр дүн биелнэ:

$$f_\Psi(\alpha) = \frac{1}{1 - \alpha} \int_\alpha^1 p[q_u(\Psi)] du.$$

Лемма 2 Ψ нь бодит утгатай санамсаргүй хэмжсигдэхүүн ба $p : \mathbb{R} \rightarrow [0, 1]$ нь эрс өсдөг фүнки байг. Тэгвэл $f_\Psi(\alpha)$ тасралтгүй өсдөг фүнки байна.

Төлбөрийн чадварын зааглалттай зээлийн хүүгийн Нэшийн загвар нь n -дүгээр тоглогч бүрийн хувьд

$$\begin{aligned} (\text{NEP}_i) \quad O_n(x) &\longrightarrow \max \\ \text{s.t. } x_n &\in X_n^i, \quad i = 1, 2, 3, \quad x_n = (x_{1,n}, \dots, x_{R,n})^T \end{aligned}$$

байх $x = (x_1^T, \dots, x_N^T)^T$ цэгийг олохоор тавигдана. Одоо тэнцвэрт зээлийн хүү оршин байх болон мэдрэмжийн шинжилгээний талаарх дараах үр дүнгүүдийг авч үзье.

Өгүүлбэр 3 (4.1)-ээр тодорхойлогдох зорилгын функцүүд, (4.2) эсвэл (4.3) эсвэл (4.4)-ээр тодорхойлогдох төлбөрийн чадварын зааглалтуудтай N тоглогчтой банкны тоглоом нь шийдтэй бөгөөд цор ганц Нэшийн хүүгийн тэнцвэрийн цэгтэй байна.

Теорем 2 x^* нь N тоглогчтой Basel II банкны тоглоомын тэнцвэрт зээлийн хүүнүүд байг. Тэгвэл,

1. Basel II өөрийн хөрөнгийн хүрэлцээний зааглалтын нөхцөлд n -дүгээр тоглогчид харгалзах зээлийн тэнцвэрт $x_{k,n}^* \in]\underline{x}_k, \bar{x}_k[$ нь загварын параметрүүдээс доорх байдлаар хамаарна:

- (i) хугарлын цэгийн $x_{i,n}$, банкны зардлын хувь e_n , дефолт болоход банкинд учрах алдагдлын хувь Δ_i , хольцын хувьсагч Ψ ба итгэх түвшин α -аас эерэгээр хамаарах бол
- (ii) мэдрэмжийн параметр $\beta_{i,n}^L$ болон капитал K_n -ээс сөргөөр хамаарна.

2. Хэрэв өөрийн хөрөнгийн хүрэлцээний зааглалт идэвхигүй бол тэнцвэрт хүү нь дараах систем тэгшигтгэлийн шийд байна:

$$M_\beta x^* = v,$$

энд

$$M_\beta = \begin{pmatrix} A_1 & 0 & \cdots & 0 \\ 0 & A_2 & \cdots & 0 \\ \vdots & \vdots & \ddots & \vdots \\ 0 & 0 & \cdots & A_R \end{pmatrix},$$

$$v = (\beta_{1,1}^L[\pi_{1,1} + e_1 + \Delta_1 p_1(\Psi)], \dots, \beta_{1,N}^L[\pi_{1,N} + e_N + \Delta_1 p_1(\Psi)], \dots, \beta_{R,1}^L[\pi_{R,1} + e_1 + \Delta_R p_R(\Psi)], \dots, \beta_{R,N}^L[\pi_{R,N} + e_N + \Delta_R p_R(\Psi)])^T$$

ба

$$A_k = \frac{1}{N-1} \begin{pmatrix} 2(N-1)\beta_{k,1}^L & -(1+\beta_{k,1}^L) & \cdots & -(1+\beta_{k,1}^L) \\ -(1+\beta_{k,2}^L) & 2(N-1)\beta_{k,2}^L & \cdots & -(1+\beta_{k,2}^L) \\ \vdots & \vdots & \ddots & \vdots \\ -(1+\beta_{k,N}^L) & -(1+\beta_{k,N}^L) & \cdots & 2(N-1)\beta_{k,N}^L \end{pmatrix}, \quad k = 1, \dots, R.$$

Тэмдэглэл 1

- (i) Хэрэв $x_{k,n}^* = \underline{x}_k$ эсвэл $x_{k,n}^* = \bar{x}_k$ бол тэнцвэрт зээлийн хүү загварын параметрүүг дээс хамаарахгүй байна.
- (ii) Basel I төлбөрийн чадварын зааглалттай Нэшийн тоглоомын хувьд Basel II-ийн үр дүнгүүд биелэхээс гадна нэмээд уг тоглоомын тэнцвэрт зээлийн хүү нь эрсдэлээр эсигнэсэн активын хуеc с болон эрсдэлийн ижин w_i -ээс эрэгээр хамаарна.
- (iii) ES төлбөрийн чадварын зааглалттай Нэшийн тоглоомын хувьд Лемма 2 ёсоор $h_i(\alpha)$, $i = 1, \dots, R$ -үүд өсдөг тасралтгүй функцууд тул Теорем 2-тэй ижил үр дүн биелнэ.
- (iv) Хэрэв Ψ нь дурын санамсаргүй хэмжсигдэхүүн ба $p_i(\cdot)$, $i = 1, \dots, R$ -үүд өсдөг функцууд бол монотон функцын дифференциалын Лебегийн теорем ёсоор (see [?]), $q_i(\cdot)(\Psi)$ болон $r_i(\cdot)$ тоологдом тооны үл дифференциаллагдах цэгүүдтэй. Иймд тэнцвэрт зээлийн хүү нь холыцуун санамсаргүй хэмжсигдэхүүн Ψ болон итгэх түвшин α -аас бараг хaa ч эерэг хамаарах ба бусад параметрүүдийн хувьд Теорем 2-тэй ижил үр дүн биелнэ.
- (v) Дээр авч үзсэн загваруудыг олон-үетэй загвар луу өргөтгөх боломжтой.

Тэмдэглэл 2 Дээр тодорхойлсон зээлийн хүүний өрсөлдөөний загварыг зээл болон хадгаламжийн хүүний өрсөлдөөний загвар руу шууд өргөтгөж болно. Тухайлбал, банкны зах зээлд нийт S тооны хадгаламжийн бүтээгдэхүүн (харилцах, хугацаагүй хадгаламжс гэх мэт) оршин байдаг, j -дүгээр хадгаламжийн бүтээгдэхүүний хэмжээ $D_{j,n}$ ба харгалзах хүү нь $y_{j,n}$ байг. Тэгсэл

$$\begin{aligned} O_n(x, y) &= \sum_{i=1}^R L_{i,n} \left(1 - \beta_{i,n}^L \left(\frac{x_{i,n}}{m(x_{i,n})} - 1 \right) \right) (x_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) \\ &\quad - \sum_{j=1}^S D_{j,n} \left(1 + \beta_{j,n}^D \left(\frac{y_{j,n}}{m(y_{j,n})} - 1 \right) \right) y_{j,n}, \end{aligned}$$

энд $\beta_{j,n}^D > 0$ нь хадгаламжийн хүүний мэдрэмжийн параметр, $y = (y_1^T, \dots, y_N^T)^T$, $y_n = (y_{1,n}, \dots, y_{S,n})^T$, $n = 1, \dots, N$. Энэ тохиолдолд Ψ нөхцөл дэх Basel II төлбөрийн чадварын зааглалт доорх байдлаар өгөгдөнө.

$$g_n^1(x_n, y_n) = K_n + \sum_{i=1}^R L_{i,n} (x_{i,n} - e_n - \Delta_i p_i(\Psi)) - \sum_{j=1}^S D_{j,n} y_{j,n} - \sum_{i=1}^R L_{i,n} \Delta_i p_i(q_\alpha(\Psi)).$$

Энэхүү зээл хадгаламжийн хүүгийн Нэшийн тоглоом нь цор ганц тэнцвэрийн цэгтэй ба мэдрэмжийн шинжисүйгээ нь төстэй байдлаар хийгдэнэ. Хэрэв бодлого боловсруулагчид зээлийн хүүгийн тааз (дээд хязгаар) тогтоохыг хүсээж байгаа бол тэд энэ загварыг ашиглан оновчтой зээл хадгаламжийн хүүгийн хэмжээг тогтоон энэхүү шинэ таазын нөлөөг урьдчилан мэдэржс чадна.

Тэмдэглэл 3 O_n хөжсүүлийн функцуу X_n^1 эсвэл X_n^2 эсвэл X_n^3 стратегийн олонлогтой нэг лидер, $N=1$ дагажтай банкны Стакелбергийн тоглоомын хувьд Стакелбергийн тэнцвэр оршин байхыг харуулж болно.

4.2 Тоон туршилт

